



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад  
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 28,000,000.00 (хорин найман сая) төгрөгийн балансын үнэ, 22,031,944.20 (хорин хоёр сая гучин нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг хорин мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан автомашиныг Улсын Ерөнхий Прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ч.Саранжав, Улсын Ерөнхий Прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 3 дугаар сарын 20 ны өдрийн  
 63 дугаар тогтоолын хэвсрэлт



"Эрчим хүчний хөгжлийн төв" төрийн өмчит үйлдвэрийн газраас  
 Улсын Ерөнхий Прокурорын газарт балансаас балансад шилжүүлэх автомашин

Д/д	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Киа Оптима 0, 01-82 УНЕ, KNAGN411BB109338, Суудлын автомашин	2011/2011	82966	28,000,000.00	22,031,944.20	5,968,055.80
<b>Нийт дүн</b>				28,000,000.00	22,031,944.20	5,968,055.80
<b>Нийт дүн</b>				(хорин найман сая)	(хорин хоёр сая гучин нэгэн мянга есөн зуун дөчин дөрвөн төгрөг хорин мөнгө)	(таван сая есөн зуун жаран найман мянга тавин таван төгрөг наян мөнгө)